



Иргэний Нисэхийн Ерөнхий газар

**Холбоо, навигаци, ажиглалтын дэд ажлын хэсгийн анхдугаар
хурал (MANPING-CNS SG/1)
(CRV АБ/1)**

Улаанбаатар, Монгол Улс, 2019 оны 6 дугаар сарын 21

Хэлэлцэх асуудал 2: Бүс нутгийн хэмжээнд мэдээлэл дамжуулах виртуал бие даасан сүлжээ

APAC бүсийн хэмжээнд мэдээлэл дамжуулах бие даасан виртуал сүлжээг зохион байгуулах ажлын хэсгийн 6 дахь удаагийн хурлын шийдвэр

МОНГОЛ УЛС

(Бүс нутгийн хэмжээнд мэдээлэл дамжуулах бие даасан виртуал сүлжээний ажлын баг)

ХУРААНГУЙ

Энэхүү мэдээллийн танилцуулга (IP)-аар ОУИНБ-ын Ази/Номхон далайн Бүс нутгийн хэмжээнд мэдээлэл дамжуулах бие даасан виртуал сүлжээний зохион байгуулалтын ажлын хэсгийн 6 дахь хурал (CRV OG/6) болон тус хурлын шийдвэрийг танилцуулна.

1. ТАНИЛЦУУЛГА

- 1.1 APAC Бүс нутгийн хэмжээнд мэдээлэл дамжуулах бие даасан сүлжээний үйл ажиллагааны зохицуулалтын ажлын багийн 6-дугаар хурал (CRV OG/6) нь 2019 оны 06 дугаар сарын 8-аас 11-ний өдрүүдэд Тайландын Вант Улсын Бангкок хотноо зохион байгуулагдсан. Тус хуралд 18 улс, ICCAIA (Aireon) болон PCCW Global гэсэн 2 компанийн нийт 70 төлөөлөгч оролцсон.
- 1.2 ОУИНБ-ын Ази/Номхон далайн бүсийн захирлын нэрийн өмнөөс APAC бүсийн төвийн CNS хариуцсан мэргэжилтэн Mr. Luo Yi хурлын үйл ажиллагаанд амжилт хүсэж, Иргэний нисэхийн дарга нарын баталсан Бээжингийн тунхаглалд туссан улс орнууд 2020 оны эцэс гэхэд CRV-ийн хэрэгжилтийг хангах шаардлагатай тухай зорилтыг биелүүлэхийг онцлон тэмдэглэв.
- 1.3 Тус хурлаар 9 мэдээллийн танилцуулга (IP), 9 хэлэлцүүлгийн танилцуулга, PCCW global компаниас CRV хэрэгжилтийн тайлан танилцуулсан бөгөөд үүнээс 3 хэлэлцүүлгийн асуудал SWIM TF/3-тай хамтран зохион байгуулагдсан. CRV OG/6 хурлаас 3 шийдвэрийн төсөл гарсан.

2. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

- 2.1 **Шийдвэрийн төсөл CRV OG/6/1-** CRV хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө болон хэрэгжилтийн хүснэгтийг тусдаа баримт бичиг болгож салгах:

Энэ нь CRV-ийн Хэрэгжилтийн Төлөвлөгөөний хэрэгжилтийн статус хүснэгтийг тусад нь салгаж, CRV-ийн хэрэгжилтийн явцыг цаг тухайд нь сайжруулах. Төлөвлөгөөнөөс хэрэгжсэн ажлуудын хүснэгтийг хасна.

- 2.2 **Шийдвэрийн төсөл CRV OG/6/2 –** CRV үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчдийг холбох үйл ажиллагаа

CRV-ын хэрэглээг нэмэгдүүлснээр үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгчдийн үйл ажиллагааг үр дүнтэй зохицуулах, хянах, үйлчилгээний чанарыг сайжруулснаар харилцаа холбооны зардлыг цаашид бууруулж чадна.

- 2.3 **Шийдвэрийн төсөл CRV OG/6/3 –** CRV тэргүүлэгч улсууд (Pioneer State)-болон ICAO APAC бүсийн төвөөс хамран гаргасан үйлчилгээний гэрээ (MSA) –г бусад улсууд мөрдөж ажиллах

Үүнд:

1. CRV OG/6 хурлаас тэргүүлэгч улсууд CRV-ийн аюулгүй байдалд хараат бус үнэлгээ хийхэд ашиглах хөрөнгийг батласан;
2. Тэргүүлэгч улс бүрээс нэг төлөөлөгч ажлын хэсэг оролцохыг санал болгосон. Тус ажлын хэсгийн даалгавар нь:
 - а) ажлын цар хүрээ тогтоох;
 - б) ОУИНБ-ын APAC бүс нутгийн байгууллагатай хамтарч үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэх.

Шаардлага: Тэргүүлэгч улсуудад явуулсан судалгааны үр дүнг үндэслэн CRV-ийн аюулгүй байдлыг хангах зорилгоор бие даасан, хөндлөнгийн байгууллагаар кибер аюулгүй байдлын үнэлгээ хийлгэх удирдамж гаргах

3. Хурлын үр дүн:

- 3.1 Оролцогчдоос:

- а) Шийдвэрийн төсөл танилцуулах, хэлэлцүүлэх;
- б) Холбогдох бусад асуудлууд

— ТӨГСӨВ —